



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/44

Ховд

Зөвлөх багийн гишүүдийн цалинг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны А/803 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зөвлөх багийн гишүүдийн цалингийн хэмжээг Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 6 дугаар жагсаалтын ТҮ-7,2-д Нягтлан бодогч, программист, сүлжээний инженер, хуулийн зөвлөх, архитекторч, технологичтой жишиж тогтоон хавсралтаар баталсугай.

2.Зөвлөх багийн цалинг хавсралтын дагуу 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож захиалагчийн хяналтын зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал нар зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 02-ны өдрийн
А/44 дүгээр захирамжийн хавсралт



ЗӨВЛӨХ БАГИЙН ГИШҮҮДИЙН НЭГ САРЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Төгрөгөөр/

д/д	Албан тушаал	Овог нэр	Цалингийн хэмжээ	Нийгмийн даатгал	1-4-р сар ажиллах
1	Зөвлөх ахлагч багийн	Д.Эрдэнэбат	766 481	99 643	3 464 496
2	Зөвлөх гишүүн багийн	Э.Нямдорж	766 481		3 065 924
3	Зөвлөх гишүүн багийн	Г.Нэмэхбаяр	766 481		3 065 924
4	Зөвлөх гишүүн багийн	Г.Билгүүн	766 481	99 643	3 464 496
	Нийт				13 060 840

-оОо-